WHITEPAPER 2021

Digital Exchange Coin

TRD COIN ТАНИЛЦУУЛГА

trade

Digital Exchange Coin

НЭГ. DIGITAL EXCHANGE COIN (TRD)	
Койны нэр	Digital Exchange Coin
Койны тиккер	TRD
Койны хаяг	0xfc49167b119d0cdccfbfccc919628e7eacdfddd8
Койн гаргагч	Дижитал эксчейнж монголиа ХХК
Койны стандарт	BEP20
Нийт гаргах койны тоо хэмжээ	20,000,000,000
Койны нэгж үнэ	1 төгрөг
Бүртгэл	Trade.mn криптовалютын бирж
Олборлолт	Олборлолт буюу майнинг хийх боломжгүй

1.2 TRD Койны тухай

TRD койн нь trade.mn биржийн өөрийн койн бөгөөд Binance Smart Chain (BSC) бүртгэлтэй Монголын анхны койн гэдгээрээ онцлог. Binance нь дэлхийн тэргүүлэх криптовалютын бирж бөгөөд өөрийн блокчэйн бүртгэлийн платформыг нэвтрүүлсэн. Энэхүү сүлжээ нь технологийн сайн шийдэл бүхий, хурдан, шимтгэл бага гэхчилэн олон давуу талуудтай.
TRD койныг дараах байдлаар хэрэглэх боломжтой.

- Төгрөг болон суурь койны хослолоор арилжаалах
- Бүх төрлийн хослолын арилжааны шимтгэлд тооцуулах
- Койн болон токен бүртгүүлэх шимтгэлийг төлбөр тооцоо хийх
- Бусад шимтгэлүүдийг төлөх

1.3 Койн хуваарилалт, зарцуулалтын төлөвлөгөө

TRD койны хуваарилалт дараах байдлаар хийгдэнэ.

ТОО ХЭМЖЭЭ	ХУВЬ	ЗОРИУЛАЛТ
7,800,000,000	39%	Дараах зориулалтын дагуу хуваарилна. - Trade.mn биржийн үнэнч хэрэглэгчдийг урамшуулал - Шинэ хэрэглэгчдэд зориулсан урамшуулал - Бүх төрлийн хослолын арилжааны шимтгэл төлөлтийн урамшуулал - Арилжаанд идэвхтэй оролцогчдод зориулсан урамшуулал - Шинэ койн, токены бүртгэлд зориулсан урамшуулал
12,200,000,000	61%	Биржийн одоогийн хувьцаа эзэмшигч нарт хуваарилагдах ба хуваарилалт хийгдсэнээс хойш 18 сарын турш арилжаалах боломжгүй байна.

ХОЁР. КОЙН ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

2.1 Компанийн тухай

Дижитал эксчейнж монголиа ХХК нь Монгол улсын анхны криптовалютын бирж болох www.trade.mn онлайн платформыг 2017 оны 10-р сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Энэхүү платформ хэрэглээнд нэвтэрснээр Монголчууд бид дэлхийн хөгжингүй улсуудтай мөр зэрэгцэн, олон улсын 400 гаруй криптовалютын биржид арилжаалагдаж буй криптовалютуудын арилжаанд эх орондоо, хурдан шуурхай, хялбар оролцох боломжтой болсон билээ.

Манай хэрэглэгчид өдөр бүр, тасралтгүй нэмэгдэж 160 гаруй мянгад хүрээд байгаа бөгөөд дэлхийн бусад тэргүүлэгч биржүүдтэй адил 7/24/365 хоногийн туршид тасралтгүй ажиллаж байна. Арилжааны самбарт 13 бүртгэлтэй криптовалютын 26 хослол арилжаалагддаг. Харилцагч, хэрэглэгчид маань веб платформ, мобайл аппликэйшн, криптовалютын ATM ашиглан арилжаанд оролцдог.

2.2 Trade.mn криптовалютын биржийн онцлог, давуу тал

Trade.mn арилжааны платформ нь криптовалютын арилжаанд оролцох сонирхолтой хувь хүн, байгууллага бүртгэл хийлгэхээс эхлэн зарлага хийх хүртэлх бүхий л үйлдлийг хялбаршуулж, автоматжуулсан бүрэн онлайн, Дижитал бирж юм.

Trade.mn бирж нь дараах онцлог, давуу талуудтай.

- Монгол улсын анхны бүрэн цахимжсан, дижитал бирж
- Олон улсын шилдэг нууцлал, хамгаалалт бүхий криптовалютын өөрийн wallet, олон улсад бүртгэлтэй full node service-үүдтэй
- Хамгийн олон блокчэйн сүлжээний бүртгэлтэй
- Хамгийн удаан аюулгүй, найдвартай, тасралтгүй ажилласан арилжааны систем, wallet, блокчэйн бүртгэлийн систем
- Олон улсын TIER II дата төвд байршдаг
- Оюуны өмчөөр хамгаалагдсан
- 24/7/365 цагийн тасралтгүй ажиллагаа
- Монголын анхны криптовалютын ATM
- Хамгийн олон харилцагч, хэрэглэгчидтэй

2.3 Trade.mn орлогын эх үүсвэр

Биржийн орлогын эх үүсвэр

- Арилжааны шимтгэл
- Бэлэн мөнгө /фиат/ болон криптовалютын зарлагын шимтгэл
- Койн, токен бүртгэл хийх шимтгэл

Цаашид нэмэгдэх орлогын төрлүүд

- Маржин арилжааны шимтгэл
- Бусад шимтгэл: Гуравдагч байгууллага, хувь хүмүүст зориулсан нэмэлт бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамж

ГУРАВ. TRD КОЙН ЭЗЭМШИГЧДЭД БИЙ БОЛОХ БОЛОМЖ, ҮР ӨГӨӨЖ

Койн эзэмшигч нар дараах боломж, өгөөжийг хүртэнэ

- Улирал бүр цэвэр ашгаа 100 хувь Койн эзэмшигч нарт хувь тэнцүүлэн хуваарилна. Бирж нь улирал бүр санхүүгийн тайлангаа гаргаж, койн эзэмшигчдэдээ нээлттэй тайлагнана.

- 1,000,000,000 койн эзэмшигч нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдох эрхтэй. Цэвэр ашгаас хүртэхээс гадна компанийн үйл ажиллагааны удирдлагад оролцоно.

Тайлбар: *Дижитал эксчейнж монголиа ххк нь мэдээллийн технологийн хурдацтай хөгжил, дэвшилтэй уялдуулан биржийн койныг гаргаж байна. Тус койн нь хөрөнгө оруулалт татах зорилгогүй. Энэхүү танилцуулга нь зөвхөн мэдээлэл өгөх зорилготой бөгөөд уг койныг худалдах эсвэл худалдан авахыг санал болгоогүй болно.*

trade

www.trade.mn